Ясны бэртэл гэмтлийг монгол анагаах ухааны яс барихзаслын аргаар эмчилсэн эмнэлзүйн тохиолдолууд

Б.Цэнд-Аюуш[1], Б.Болорцэцэг[2]

[1]Архангай аймаг дахь АШУҮИС-ийн Цогцолборын Эмнэлэг Уламжлалтын тасаг
[2]АШУҮИС -ийн зүү эмчилгээ судлал резидэнт
Цахим шуудан: tsend-ayush.b@mnums.edu.mn, Утас: 99336331

Түлхүүр үг:

Ясны бэртэл
Монгол
анагаах ухаан
Яс барих засал

Товч утга: Монгол уламжлалт яс барих засал бол тархины сэргэг, цээжний урлаг, хийгийн хүчээр архи үлээж гарын эрдмээр ясны бэртлийг засах өвөрмөц онцлогтой, ясны хугаралтай өвчтөнд зохицсон анагаах ухааны эрдэм мэргэжил болно.[1] Энхүү засал нь өвчтөн өөрийн өвчнөө эдгээх төрөлх чадварыг төгс бадруулан, бэртсэн ясны өөрөө эдгэрэх дотоод нууцыг бүрэн илрүүлж бэртсэн ясны хальс ба цусны гүйдлийг гэмтээхгүй, хөдлөнгүй тогтонгуйг уялдуулна. Иймээс өвчтөнд зовиур бага, арьс мах нь шархлахгүй, бусад өвчин давхацах нь бага, эмчилгээний хугацаа богино, ясны бороо үүсэх нь хурдан, гэмтсэн үеийн ажиллагаа сэргэх нь хурдан бөгөөд эмчилгээний зардал бага зарцуулах гэх мэт олон талын давуулаг онцлогтой нэг зүйлийн мэс засал хийхгүй Монгол эмнэлгийн шинжлэх ухаан болох юм.[2] **Эмнэлзүйн тохиолдол:** Өвчтөн М, 10 Настай, эрэгтэй “Бугалга ясны гадар шонтонгын хугарал”, Өвчтөн С, Өвчтөн Ж, эмэгтэй “Шуу ясны хугарамтгай хэсгийн хугарал“ Colles fracture, Өвчтөн Б, 5-р алга ясны хугарал “V шивнүүр ясны хугарал”, Өвчтөн Б, «Мөр эгэмний үеийн мултрал» зэрэг эмнэлзүйн тохиолдолуудад Уламжлалт яс барих заслын аргаар эмчилгээг хийв. **Эмчилгээ**: Уламжлалт яс барих заслын аргаар гэмтсэн ясыг гар аргаар орошуулан, модон хавтасаар гадар бэхэлж тогтоон, эмчилгээний хугацаанд дотроос эм хэрэглэн, эмчилгээний бүх хугацаанд тохирсон ажиллагааны боловсрол хийх. **Үр дүн:** Нийт эмчилгээний хугацаа 21-28 хоног дээр ясны бороо үүсч мөчдийн хөдөлгөөн сэргэн ажиллагаа сайжирсан. **Дүгнэлт:** Дээрх эмнэлзүйн тохиолдлуулад уламжлалт яс барих заслын аргыг ашиглан эмчилгээ хийхэд эмчилгээний үр дүнг сайн байна. зарим талаар европ анагаах ухааны эмчилэх арга мэргэжилээс илүү давуу талтай байж болох бөгөөд европ анагаах ухааны аргатай адил эмчилгээнд хэрэглэж болох юм.

Эмнэлзүйн тохиолдол 1. Өвчтөн 10 Настай эрэгтэй “Бугалга ясны гадар шонтонгын хугарал”
Өвчтөн 4 хоногын өмнө морьноос унаж гарын бугалга ясны доор хэсгээр хавдаж өвдөн хөдөлгөөн хязгаарлагдах болсон гэнэ.

Зовуурь: Баруун талын тохойн үеээр хавдаж өвдөнө, арьсан доор цус хурсан үеийн хөдөлгөөн хязгаарлагдана, өвдөлт их

Оношь: “Бугалга ясны гадар шонтонгын хугарал”

Асуух шинжилгээ: өвчний түүх Өвчтөн 4 хоногын өмнө морьноос унасан түүхтэй

Үзэх шинжилгээ: өвчтөн баруун гарын тохойн үеээр хавдсан арьсан доор цус гаран хөхөрсөн.

DR: Тохой үеийн эгц болон хажуугын рентген зурагт атгалын гадар шонтон эмтэрч байр шилжсэн байдалтай, (Capitellum яс өсөлтийн зон дайрч хугарсан).

Хүрэлцэх: Дарахад ясны үрэлдэх чимээ гарна эмзэглэл их

Эмчлэх зарчим: Гэмтсэн ясыг гэргүүлж түлхэх, нухаж дарах зэрэг гар аргаар орошуулан, модон хавтасаар гадар бэхэлж тогтоон, эмчилгээний хугацаанд дотроос эм хэрэглэн, эмчилгээний бүх хугацаанд тохирсон ажиллагааны боловсрол хийлгэх.

Эмчилгээний хугацаа: 21 хоног болоход гадар бэхэлж тогтоосон модон хавтасыг авч ажиллагааг сэргээх хөдөлгөөн засал хийсэн

Эмчилгээний үр дүнг: 21 хоногын эмчилгээний дараа бэхэлгээг авах үед ясны бороо бүрэн үүссэн, үеийн хөдөлгөөний далайц муудсан байдалтай байсан бол 28 хоногын эмчилгээний дараа үеийн хөдөлгөөн эрс сайжирч өвдөх зовуурь үгүй болсон байна.



Зураг 1. A. Эмчилгээний өмнөх рентген зураг
B. Эмчилгээний дараах рентген зураг
C. Уламжлалт яс барих заслын аргаар гадар бэхэлсэн байдал

Тохиолдол 2. Өвчтөн С, эмэгтэй "Шуу ясны хугарамтгай хэсгийн хугарал" Colles fracture
Өвчтөн халтирч унах үед гарын алгаар тулан унасан гэнэ унах үед яс хугарах чимээ гарсан гарын шуу бугуйн хэсгээр хавдан өвдөж илт мурийсан гэнэ

Зовуурь: Зүүн бугуйн үеээр хавдаж арьсан доор цус гарсан, өвдөлт их, хөдөлгөөн хязгаарлагдсан.

Онош: "Шуу ясны хугарамтгай хэсгийн коллис хэлбэрийн хугарал"

Асуух шинжилгээ: Өвчний түүх өвчтөн халтирч унах үед гарын алгаар тулан унасан гэнэ.

Үзэх шинжилгээ: Өвчтөн зүүн гарын бугуй шуу хэсгээр хавдсан арьсан доор цус гаран хөхөрсөн, илэрхий хотойж байр шилжсэн гарын сарвуу чинэрч хавдсан.

DR: Бугуйн үеийн эгц болон хажуугын рентген зурагт Шуу ясны хугарлын төвийн үзүүр арагш доош байр шилжсэн байдалтай.

Хүрэлцэх: Дарахад ясны үрэлдэх чимээ гарна эмзэглэл их

Эмчлэх зарчим: Гэмтсэн ясыг сугсарч татах, дарж шашах аргаар орошуулан, ясны хугарлын зөрүү үүссэн чиглэлийг үндэслэн жиирэг тавин, модон хавтасаар гадар бэхэлж тогтоон, эмчилгээний хугацаанд дотроос эм хэрэглэн, эмчилгээний бүх хугацаанд тохирсон ажиллагааны боловсрол хийлгэх.

Эмчилгээний хугацаа: 28 хоног болход гадар бэхэлж тогтоосон модон хавтасыг авч ажиллагааг сэргээх хөдөлгөөн засал хийсэн

Эмчилгээний үр дүнг: 28 хоногын эмчилгээний дараа бэхэлгээг авах үед ясны бороо бүрэн үүссэн, бугуйн үеийн хөдөлгөөний далайц муудсан байдалтай байсан бол 36 хоногын эмчилгээний дараа үеийн хөдөлгөөн эрс сайжирч өвдөх зовуурьгүй болсон байна.



Зураг 2. A. Эмчилгээний өмнөх рентген зураг, B. Эмчилгээний дараах рентген зураг,
C. Эмчилгээний өмнөх рентген зураг, D. Эмчилгээний дараах рентген зураг,
E. Уламжлалт яс барих заслын аргаар гадар бэхэлсэн байдал

Эмнэлзүйн тохиолдол 3. Өвчтөн Б, эрэгтэй “5-р алга ясны хугарал” V шивнүүр ясны хугарал
Өвчтөн 1 хоногын өмнө гараар хүчтэй зүйл цохиж гэмтэл авж гарын алга орчим хавдан өвдөх болж гараа атгаж чадахгүй болсон гэнэ.

Зовуурь: Баруун талын гарын алга хэсэг хавдаж өвдөнө. Гараа атгаж чадахгүй алганы гадар хэсэг өвдөлт их, чигчий хуруу хөдөлгөхөд өвчин ихсэнэ.

Оношлогоо: “5-р алга ясны хугарал”

Асуух шинжилгээ: Өвчний түүх Өвчтөн 1 хоногын өмнө гараар хүчтэй зүйл цохиж гэмтэл авсан түүхтэй.

Үзэх шинжилгээ: Өвчтөн баруун гарын алга хэсгээр хавдсан арьсан доор цус гаран хөхөрсөн, 5-р алга аяны хэсэгт дарахад өвдөлт их.


DR: гарын сарвуу хэсэг эгц болон жишүү рентген зураг 5-р алга ясны биеийн дунд хэсэгт ташуу байр шилжсэн хугаралтай.

Хүрэлцэх: Дарахад ясны үрэлдэх чимээ гарна эмзэглэл их

Эмчлэх зарчим: Гэмтсэн ясыг гохтон татах, чимхэж нитрэх зэрэг гар аргаар орошуулан, модон хавтасаар гадар бэхэлж тогтоон, эмчилгээний хугацаанд дотроос эм хэрэглэн, эмчилгээний бүх хугацаанд тохирсон ажиллагааны боловсрол хийлгэх.

Эмчилгээний хугацаа: 28 хоног болоход гадар бэхэлж тогтоосон модон хавтасыг авч ажиллагааг сэргээх хөдөлгөөн засал хийсэн

Эмчилгээний үр дүнг: 28 хоногын эмчилгээний дараа бэхэлгээг авах үед ясны бороо бүрэн үүссэн, гар сарвуу хөдөлгөөн муудсан байдалтай байсан бол 36 хоногын эмчилгээний дараа үеийн хөдөлгөөн сайжирч өвдөх зовуурь үгүй болсон байна.



Зураг 3. A. Эмчилгээний өмнөх рентген зураг,
B. Эмчилгээний дараах рентген зураг,
C. Уламжлалт яс барих заслын аргаар гадар бэхэлсэн байдал

Тохиолдол № 4. Өвчтөн Б, эрэгтэй “Мөр эгэмний үеийн мултрал“
Өвчтөн морьноос унах баруун мөр хэсгээр дарж унасан гэнэ. Баруун гараа хөдөлгөх үед мөрний үеийн дээд хэсэгт өвдөж хөдөлгөөн хязгаарлагдана.

Зовуурь: Баруун гараа хөдөлгөхөд мөрний дээд хэсгээр өвчин их гараа сайн өргөж болохгүй.

Оношлогоо: “Мөр эгэмний үеийн мултрал”

Асуух шинжилгээ: Өвчтөн морьноос унах баруун мөр хэсгээр дарж унасан гэнэ

Үзэх шинжилгээ: Өвчтөн баруун мөр эгэмний холбоос хэсэгт дарахад өвчин их, хавдаж арьсан доор цус гарсан, эгэм ясны гадар үзүүр дээш гүдийсэн.

DR: Мөрний үеийн эгц рентген зураг эгэм далны холбоос буюу acromion-clavicular joint-ын зай ихэссэн.

Хүрэлцэх: Дарахад эмзэглэл ихтэй.

Эмчлэх зарчим: Гэмтсэн мөчнийг өргөж түлхэх, дарах аргаар орошуулан, тохиромжтой жийрэг тавиж уламжлалт яс барих заслын эгэм ясны гадар бэхлэх аргаар гадар бэхлэж, эмчилгээний хугацаанд дотроос эм хэрэглэн, эмчилгээний бүх хугацаанд тохирсон ажиллагааны боловсрол хийлгэх.

Эмчилгээний хугацаа: 28 хоног.



Зураг 4. A. Эмчилгээний өмнөх рентген зураг
B. Эмчилгээний дараах рентген зураг
C. Уламжлалт яс барих заслын аргаар гадар бэхэлсэн байдал

Хэлцэмж: Монголчууд бидний эрт дээр үеэс хэрэглэж ирсэн уламжлалт яс барих засал нь эртнээс аваад зөвхөн ард түмний дунд амаар ярьж биеэр заах хэлбэрээр байсан бөгөөд гэр бүлийн дотор уламжлагдан хэрэглэж байсан бол энэхүү өвөрмөц онцлог бүхий гайхамшигт заслын арга нь орчин үед эрчимтэй хөгжин дэлгэрч Хятад улсад уламжлалт яс барих засал нь их сургуулийн хичээлийн программд орж олон сурагчдад уламжлалт яс барих заслын хичээл орох болсноор олон олон сурагчид энэхүү заслын талаар мэдлэгтэй болж байгаа нь цаашид хөгжин дэлгэрэх үндэс суурь болж байна.[3-5]

Мөн одоо үеийн анагаах ухааны онол ба тоног төхөөрөмжийг ашиглан оношилох эмчлэх арга маяг нь илүү нарийн нямбай болон хөгжиж уламжлалт яс барих засал нь хүний биеийн бүх ясны хугарал, үеийн мултралыг мэс засал хийхгүйгээр эмчилэн засах хэмжээнд хүрч, ясны хугарлыг ороншуулахдаа өнгөрсөний ажиллагааны байршилд хүргэж байснаа эрүүл анатомын байранд хүргэж чадах болсон бөгөөд эдгэрэх хугацаа богино, үе мөчдийн эрүүлийн ажиллагаа сэргэх нь хурдан, гадар шархдал гэмтэл үүсэх нь бага, цусан гүйдэл мэдрэлийг гэмтээхгүй зэрэг эмчилгээний үр дүн маш сайн бөгөөд давуу тал олон. Цаашилбал ясны хугарал, үе мултралыг засах бус бүлчин шөрмөс, зөөлөн эдийн гэмтэл шархдалыг мөн эмчилэн засаж нилээд сайн үр дүнд хүрсэн байна.[6-9]

Энэ хүү засал эмчлгээ хөгжихийг дагалдаад судалгаа шинжилгээ хийх мэргэжилтэн эмч судлаачид мөн нэмэгдэн нотолгоонд суурилсан эрдэм шинжилгээний бүлээлүүд ихээр гахар болсон байна. Судлаач Сүрлэг, Б.Лагшмаа болон бусад нарын Уламжлалт яс барих заслын аргаар Шуу ясны хугарамтгай хэсгийн хугаралыг эмчилсэн эмчилгээний үр нөлөөг судалсан судалгаагаар уламжлалт яс барих заслын арга нь гипсээр бэхлэх бүлгээс эмчилгээний үр дүн сайн байсан байна.[10] Судлаач Сүргүна, Төмөрбагана нар Уламжлалт яс барих заслын аргаар Шуу ясны холын хэсгийн хугарлыг эмчилсэн эмчилгээний судалгааг хийж үр дүнд тус засал нь эмчилгээний хугацаа богино, үр дүн сайн бөгөөд зардал мөнгө бага зарцуулсан гэж тогтоосон байна.[11] Судлаач Очирбат нар хүүхдийн шуу ясны хугаралыг Уламжлалт яс барих заслын аргаар зассан эмчилгээний судалгааг хийж судалгаагаар Эмнэлзүйн практикт хүүхдийн давхар шууны хугарлыг эмчлэхэд уламжлалт яс барих заслын аргаар гар аргаар ороншуулж, жижиг хавтасаар гадар бэхэлж тогтоон эмчилэх энэ арга нь энгийн, хямд, хурдан үйл ажиллагааны эдгэрэлтийг дэмждэг бөгөөд хангалттай үр дүн өгдөг гэж тогтоожээ.[12] Судлаач Өлзий нар

Дүгнэлт: Монгол анагаах ухааны Уламжлат яс барих заслын аргаар ясны гэмтэл бэртэлийн эмчлэх нь эмчилгээний хугацаа богино, ясны бороо үүсэх нь хурдан бөгөөд эмчилгээний зардал бага, эмчилгээний үед тогтсон хөдөлгөөн заслыг хийж гэмтсэн үеийн ажиллагааг хурдан сэргээх зэрэг олон давуу талтай бөгөөд эмнэлзүйд өргөнөөр хэрэглэх цаашид хөгжүүлэх бүрэн боложтой засал юм.

Ном зүй:

1. *Бао жин шан. Бао жин шаны эмчилгээний үйлдвэр. Өвөр монголын шинжлэх ухаан техник мэргэжлийн хэвлэлийн хороо; 2012, 3 - 15.*
2. *Бу. Ачилалт. Бао жин шанын эрдэм шинжилгээний өгүүлэлийн түүвэр. Өвөр монголын шинжлэх ухаан техник мэргэжлийн хэвлэлийн хороо, 2015, 141- 146.*
3. *Жаргал Монгол анагаах ухааны яс шарханы судлал. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо; 2006-8, 1-6*
4. *Бао жин шан, Бао Хасан. Уламжлалт Ясан засал. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо; 1984-5, 3 – 7*
5. 包金山,包占宏.包氏蒙医整骨术——五千多年前草原博文化的传承与发展[J].亚太传统医药,2018,14(12):34-37.
6. 韩涛高，都嘎尔著.神奇的蒙医传统整骨　呼和浩特：内蒙古人民出版社，2011-11,7 - 19
7. 莫喜乐,阿其拉吐,包海日罕.蒙医整骨术治疗桡骨远端陈旧性骨折并畸形的临床研究[J].中国民族医药杂志,2020,26(06):61-62.DOI:10.16041/j.cnki.cn15-1175.2020.06.034.
8. 宝乌力吉,王梅,照那木拉.蒙医整骨术基于本源认知的骨折固定概念及其生命意涵[J].中华中医药杂志,2023,38(07):3407-3409.
9. 孟克布和,宝乌力吉,王红霞,照那木拉.中国蒙医整骨术整复手法概念认知及其疗效模式[J].中华中医药杂志,2021,36(08):4538-4540.
10. 苏日力格,Lagshmaa Baldoo,王秀秀,阿其拉吐,孟克布和,宝乌力吉,莫喜乐,阿拉坦格日乐,Oyuntsetseg Namsrai.蒙医整骨疗法治疗桡骨远端骨折疗效观察.亚太传统医药,2022,18(04):85-90.
11. 苏如娜,鲍伟民,杨蒙,满达,特木日巴根.蒙医整骨治疗桡骨远端骨折疗效观察.中国民族医药杂志,2019,25(04):21+29.DOI:10.16041/j.cnki.cn15-1175.2019.04.013.
12. 敖其尔巴图,吴金海.蒙医整骨术治疗儿童前臂双骨折临床疗效观察.世界最新医学信息文摘,2018,18(A3):208+227.DOI:10.19613/j.cnki.1671-3141.2018.103.164.

Clinical cases of bone fracture treated with Traditional mongolian Osteopathy

Tsend-Ayush B[1], Bolortsetseg B[2]

[1]Hospital in Arkhangai, MNUMS
[2]Acupuncture resident of MNUMS
E-mail: tsend-ayush.b@mnums.edu.mn, Tel: +976-99336331

Abstract:
Background: The Traditional mongolian Osteopathy of Mongolia is the knowledge and profession of the medicine that it blows an alcohol by the strength a chest art and brain awake; specially cares bone injury by hand as well as dedicated to the patient with the bone injury. This treatment perfectly improves the nature skill which the patient will treat own disease as well as completely detects the inside secret to recover itself of the injured bone. Also, it doesn't hurt the peel of the injured bone and blood system as well as harmonizes with a constant and without movement. So, this is one of without surgery therapy as well as the science of Mongolian hospital that it has a lot of special advantages such as a pain less, to not ulcerate skin and muscle, other combined disease less, short time of treatment, the expense less of treatment as well as the bone healing and the recovery of the injured joint function are fast.
Clinical cases: Patient M, 10 years old, male, "Fracture of the lateral condyle of the humerus", Patient C, Patient J, female, "Colles fracture", Patient B, fracture of the 5th metacarpal bone, Patient B, "Dislocation of the shoulder clavicle" were treated with Traditional mongolian Osteopathy.
Results: Results: Over a total treatment period of 21-28 days, callus formation occurred, limb mobility was restored, and function improved.
Conclusion: In the above clinical cases, the treatment effect of Traditional mongolian Osteopathy methods is good. In some ways, it may be more advantageous than European medical methods and can be used for the same treatment as European medical methods.

Keywords: Bone fracture, Mongolian medicine, Traditional Osteopathy